



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 165

Мандалговь


Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн хэлтэст Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдаж авсан 75'000 /далан таван сая/ төгрөгийн Ланд крузер-200 маркын автомашин, Цагдаагийн ерөнхий газрын санхүүжилтээр олгогдсон 10'588'600 /арван сая таван зуун наян найман мянга зургаан зуу/ төгрөгийн эд хөрөнгийг хавсралтын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа С.Батчулуунд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны ᠗ сарын
᠒᠒ өдрийн 1᠖-р тогтоолын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгө

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Ланд крузер-200	ш	1	75 000 000	75 000 000
2	Процессор/Dell Optiplex 9020/	ш	1	2 349 900	2 349 900
3	Дэлгэц /Acer Led G236/	ш	1	319 900	319 900
4	Процессор /Dell Optiplex 7010/	ш	6	1 099 900	6 599 400
5	Дэлгэц /Dell E1914/	ш	6	219 900	1 319 400
Нийт					85 588 600